

“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

АЖИЛД ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, “Бүтээлч үйлс” ХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Пүрэвжавын Оюунхүүг “Бүтээлч үйлс” ХК-ний ТУЗ-ийн даргаар 2026 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. Дамдиндоржийн Эрдэнэбилэгийг “Бүтээлч үйлс” ХК-ний гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. П.Оюунхүү, Д.Эрдэнэбилэг нарын албан тушаалын цалин, бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцон олгохыг нягтлан бодогч Э.Оюунцэцэгт зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

П.ОЮУНХҮҮ

Д.ЭРДЭНЭБИЛЭГ

Д.ЭРДЭНЭТУЛГА

О.ОЮУНЦЭЦЭГ

Д.БАЯРСАЙХАН

Л.ЦЭЦЭГСАЙХАН

Ч.АМАРЖАРГАЛ

Т.ТУНГАЛАГ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ



“БҮТЭЭЛЧ ҮЙЛС” ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурлыг 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 8-р хороо, Эрчим хүчний зүүн талд, үйлдвэрийн байр, хурлын өрөөнд 12:45 цагт эхэллээ.

Хуралд: ТУЗ-ийн гишүүн П.Оюунхүү, Д.Эрдэнэбилэг, Д.Эрдэнэтулга, О.Оюунцэцэг, Д.Баярсайхан, Л.Цэцэгсайхан, Ч.Амаржаргал, Т.Тунгалаг, Д.Эрдэнэчимэг нар оролцов.

Хурлыг ТУЗ-ийн гишүүн Д.Эрдэнэбилэг даргалав.

Хэлэлцсэн нь: ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлыг сонгох тухай

Д.Эрдэнэбилэг: ТУЗ-ийн анхны хуралдаанаа эхлэе. Хэнд ямар санал байна вэ?

О.Оюунцэцэг: Би энэ компанид олон жил ажиллаж ирлээ. Компанийг цаашид Д.Эрдэнэбилэг удирдаж явах нь зүйтэй тиймээс ТУЗ-ийн даргаар Пүрэвжавын Оюунхүүг, гүйцэтгэх захирлаар Дамдиндоржийн Эрдэнэбилэгийг сонгох саналыг оруулж байна.

Д.Эрдэнэбилэг: ТУЗ-ийн гишүүн О.Оюунцэцэгийн саналыг зөвшөөрч байна уу? Өөр саналтай гишүүд байна уу?

Гишүүд: Байхгүй, саналыг батлая.

Шийдвэрлэсэн нь: Пүрэвжавын Оюунхүүг ТУЗ-ийн даргаар, Дамдиндоржийн Эрдэнэбилэгийг гүйцэтгэх захирлаар гишүүдийн 100%-ийн саналаар томилогдов.

Хурал 13:15 минутад дуусав.


ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ЭРДЭНЭБИЛЭГ



Т.ТУНГАЛАГ



"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

АУДИТЫН ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2, 81.4 дэх заалтуудыг үндэслэн
ТОГТООХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо байгуулсугай.
- Аудитын хорооны даргаар Д.Эрдэнэбилэг, гишүүдээр Л.Цэцэгсайхан, Д.Эрдэнэчимэг нарыг сонгосугай.
- Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн заалтуудыг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.ОЮУНХҮҮ

"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2, 81.4 дэх заалтуудыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороо байгуулсугай.
2. Цалин урамшууллын хорооны даргаар П.Оюунхүү, гишүүдээр О.Оюунцэцэг, Т.Тунгалаг нарыг сонгосугай.
3. Цалин урамшууллын хороо нь Компанийн тухай хуулийн заалтуудыг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.ОЮУНХҮҮ

"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2, 81.4 дэх заалтуудыг үндэслэн
ТОГТООХ нь:

- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороо байгуулсугай.
- Нэр дэвшүүлэх хорооны даргаар Д.Эрдэнэтулга, гишүүдээр Д.Баярсайхан, Ч.Амаржаргал нарыг сонгосугай.
- Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хуулийн заалтуудыг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.ОЮУНХҮҮ